



ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ
СОНИРХОГЧ ЭТГЭЭДЭД

ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА
ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ
БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ

Их тойруу 1, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15171

Утас: 32 07 34, Факс: (976-11) 32 03 38,

Цахим шуудан: info@barilga.gov.mn

2024-10-02 № 1/2715
танай -ны № -т

Тендерийн баримт бичигт өөрчлөлт
оруулах тухай

Тус байгууллагаас зарласан БХТ/20240101298 дугаартай “Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, туршилт, тохируулга, тоног төхөөрөмжийн чанар, технологийн захиалагчийн хяналтын зөвлөх үйлчилгээ” төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгыг үндэслэн захиалагчаас тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгтэд дараах өөрчлөлтийг оруулж байна. Үүнд:

ТШЗ-ны холбогдох заалт	Өөрчлөлт
ТШЗ 19.1	<p>Техникийн чадавхи болон туршлагын шаардлага: “Шаардана”</p> <p>Үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай хүний нөөцийн мэдээлэл:</p> <p>1. Төслийн удирдагчийн ажлын туршлагад заасан 12-оос доошгүй жил ажилласан, Нуурсний чиглэлийн мэргэшлийн зэрэгтэй, үндсэн ажилтан байх (хэрэв түншлэл, туслан гүйцэтгэгч оролцож байгаа тохиолдолд толгой компанийн үндсэн ажилтан байх) гэснийг 12-оос доошгүй жил ажилласан, мэргэшлийн зэрэгтэй, үндсэн ажилтан байх,</p> <p>2. Багийн ахлагчийн ажлын туршлагад заасан 10-аас доошгүй жил ажилласан, Уул уурхайн машин, тоног төхөөрөмжийн механик инженер, аж үйлдвэрийн инженер мэргэжлээр мэргэшлийн зэрэгтэй, үндсэн ажилтан байх (хэрэв түншлэл, туслан гүйцэтгэгч оролцож байгаа тохиолдолд толгой компанийн үндсэн ажилтан байх) гэснийг 10-аас доошгүй жил ажилласан, механик инженер мэргэжилтэй, мэргэшлийн зэрэгтэй, үндсэн ажилтан байх,</p> <p>-Нийгмийн даатгалын шимтгэлийг сүүлийн 6 сар буюу 2024 оны 3, 4, 5, 6, 7, 8-р сард тухайн тендерт оролцогч аж ахуйн нэгжид тасралтгүй төлсөн байна гэснийг Нийгмийн даатгалын шимтгэлийг сүүлийн 6 сар буюу 2024 оны 4, 5, 6, 7, 8, 9-р сард тухайн тендерт оролцогч аж ахуйн нэгжид тасралтгүй төлсөн байна. Нийгмийн даатгалын лавлагааг Е-mongolia цахим хуудаснаас авч тендерт хавсаргана,</p> <p>Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн туршлага: “Шаардана”</p>

152402849

	<p>-Дээрхи онуудад ижил төстэй үйлчилгээ буюу нүүрс баяжуулах үйлдвэрийн болон нүүрс бэлтгэлийн хэсгийн барилга угсралт, үндсэн тоног төхөөрөмжийн угсралтын ажил гүйцэтгэсэн байна гэснийг Дээрхи онуудын аль нэг жилд ижил төстэй үйлчилгээ буюу баяжуулах үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжийн угсралтын ажил гүйцэтгэсэн байна гэж тус тус өөрчлөлт оруулав.</p>
ТШЗ 19.3	<p>Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: “Шаардана” Барилга, хот байгуулалтын яамнаас олгосон: -Хөнгөн ба хүнд үйлдвэрийн барилга байгууламжийн технологийн зураг төсөл -Уул уурхайн технологийн зураг төсөл, ТЭЗҮ гэснийг Барилга, хот байгуулалтын яамнаас олгосон /тухайн үеийн/: 1. ЗТ-3.3 Хөнгөн ба хүнд үйлдвэрийн болон агуулахын барилга байгууламжийн технологийн зураг төсөл ЭСВЭЛ 3T-4.3 Хөнгөн ба хүнд үйлдвэрийн барилга байгууламжийн технологийн зураг төсөл 2. ЗТ-3.7 Уул-уурхайн технологийн зураг төсөл, ТЭЗҮ ЭСВЭЛ 3T-4.7 Уул-уурхайн технологийн зураг төсөл, ТЭЗҮ ЭСВЭЛ 3T-5.5 Уул-уурхайн технологийн зураг төсөл, ТЭЗҮ гэж өөрчлөлт оруулав.</p>

Өөрчлөгдсөн тендерийн баримт бичгийг худалдан авах ажиллагааны цахим систем [/www.tender.gov.mn/-ийн тухайн төсөл](http://www.tender.gov.mn/), арга хэмжээний Тендерийн баримт бичиг хэсэгт шинэчлэн байршуулсан болно.

Ажлын даалгавар, үнэ, тоо хэмжээнд өөрчлөлт ороогүй тул тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгахгүй болохыг мэдэгдье.

